



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/40

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 1.2 дахь заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны “2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 16/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан Өвөрмөдот 1-р багийн нутаг “Шүдгүй ар” гэх газарт Жуулчны баазын зориулалттай 2 га газрыг 30 жилийн хугацаатайгаар эзэмшүүлэхээр газар эзэмшүүлэх эрхийн дуудлага худалдааг цахимаар 2024 оны 05 дугаар сарын 28-нд явуулсугай.

2. Дуудлага худалдаа явагдах зар мэдээг хуулийн дагуу иргэдэд мэдээлэхийг Газрын даамал (Ц.Нямдорж)-д, хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Б.Бямбасүрэн) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Д.БАТБАЯР

622401080

D:Alban bichig;Zahiramj 2024



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А153

Хужирт сум

Дуудлага худалдаа явуулах ажлын
хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам"-ын 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Л.Цэдэв (Хууль, эрхзүй хариуцсан мэргэжилтэн)

Дуудлага худалдааны хөтлөгч: Ц.Нямдорж (Газрын даамал)

Тэмдэглэл хөтлөгч: Д.Мөнхбат (Бэлчээр, газар тариалангийн асуудал
хариуцсан мэргэжилтэн)

2.Ажлын хэсгийн ахлагч (Л.Цэдэв)-д даалгах нь:

а.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 208 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал"-ын дагуу тогтоож, зохих журмын дагуу Газрын цахим биржийн www.mle.mn хаягаар дуудлага худалдааг зохиох

б.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллах.



ДАРГА

Д.БАТБАЯР

622401106

D:Alban bichig;Zahiramj 2024